

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-6

1. “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн төсөл /Монгол Улсын Засгийн газраас 2025.03.06-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/ 3-6

**Монгол Улсын Их Хурлын
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 12 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Н.Алтаншагай, Э.Болормаа, Д.Ганбат, Х.Жангабыл, Н.Наранбаатар, П.Наранбаяр, Д.Цогтбаатар, Ө.Шижир, Б.Энхбаяр, Ж.Энхбаяр, Л.Энхнасан;

Чөлөөтэй: Д.Энхтүвшин.

Нэг. “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн төсөл /Монгол Улсын Засгийн газраас 2025.03.06-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын дарга Ч.Нарантуяа, Цагдаагийн ерөнхий газрын дарга Т.Сүхболд, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 4

Бүгд: 13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Р.Эрдэнэбүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул санал хураалтын дүнг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, дэмжсэнээр тооцов.

Нийт 13 гишүүнээс 10 гишүүн дэмжиж, 76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 12 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 11 минут үргэлжилж, 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
12 цаг 12 минут.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна. 2025 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Ингээд ирцийг танилцуулъя. Очирбатын Амгаланбаатар гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Энхтайваны Бат-Амгалан гишүүн, Батын Батбаатар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Нямтайширын Номтойбаяр гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн, Равжихын Эрдэнэбүрэн гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Нэг асуудал байгаа. “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн төсөл, Засгийн газар 25 оны 3 сарын 6-ны өдөр ирүүлсэн зөвшилцөх асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцэж эхэлье.

Уг асуудлыг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Ням-Осорын Учрал сайд танилцуулна. Таныг микрофонд урьж байна.

Н.Учрал: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын гадаад харилцаа өргөжин хөгжихийн хэрээр иргэдийн гадаадад суралцах, ажиллах болон бизнес, аяллын чиглэлээр харилцан зорчих явдал нэмэгдэж байгааг харгалзан Монголчууд ихээр зорчиж, амьдарч, ажил хөдөлмөр эрхэлдэг улс орнуудтай эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ, хэлэлцээр байгуулах асуудалд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас анхаарал хандуулан ажиллаж байна.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийг байгуулах саналыг анх Чехийн талаас гаргаж, хэлэлцээрийн төслийг ирүүлсэн бөгөөд манай талаас өөрийн саналыг хүргүүлж хамтран ажилласнаар талууд хэлэлцээрийн төслийг эцэслэн тохироод байна.

Энэхүү хэлэлцээрийн төсөл нь 5 хэсэг, 29 зүйл, хавсралтаас бүрдэж байгаа бөгөөд хэлэлцэн тохирогч талууд олон нийтийн аюулгүй байдлыг хангаж, нийтийн хэв журмыг сахиулахад зохион байгуулалттай гэмт хэрэгтэй хамтран тэмцэх, урьдчилан сэргийлэх, хоёр улсын эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааны тусгай хэлбэр, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэрэг бүртгэх, мөрдөн байцаах шатанд шалгагдаж байгаа гэмт хэргийн талаар мэдээлэл солилцох, нөгөө талын хүсэлтийг үндэслэн гэмт этгээд, гэрч, хохирогчоос тайлбар, мэдүүлэг авах, албан хаагчдыг тодорхой даалгавар гүйцэтгүүлэхээр нөгөө талын нутаг дэвсгэрт томилон ажиллуулах, нууцад хамаарах баримт бичиг болон хүний хувийн мэдээлэл харилцан солилцох журам, түүнчлэн хамтарсан сургалт, семинар, дадлага, сургуулилт зохион байгуулах, мэргэжилтнүүдээ бэлтгэх зэрэг харилцааг зохицуулсан.

Уг хэлэлцээрийг байгуулснаар зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, гэмт хэргийн зохион байгуулагчийг олж тогтоох чиглэлд талуудын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, олон нийтийн аюулгүй байдал, хэв журам зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлд хоёр улсын эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо шууд харилцаж, түргэн шуурхай хамтран ажиллах боломжтой болох юм.

Иймд олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад Улсын Их Хурал эрх зүйн туслалцаа үзүүлэх гэмт этгээд болон ялтан шилжүүлэхтэй холбогдсон олон улсын гэрээг заавал соёрхон батална гэж заасны дагуу соёрхон батлах олон улсын гэрээнд хамаарч байх тул олон улсын гэрээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу холбогдох шийдвэрийн төслийг боловсруулан танилцуулж байна.

Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн яам Нарантуяа, Хууль зүй, дотоод хэргийн яамны Олон улсын гэрээ, гадаад хамтын ажиллагааны газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Бригадын генерал Сүхболд, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, Хурандаа Батзориг гэсэн ийм бүрэлдэхүүнтэй оролцож байна.

Ингээд хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг танилцуулна.

П.Сайнзориг: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 3 дугаар сарын 6-ны өдөр “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Бүгд

Найрамдах явах улс хоорондын хэлэлцээр"-ийн төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр Улсын Их Хуралд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 2025 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээрийн төслийг зөвшилцөх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир энэ төрлийн хэлэлцээрийг өөр улс оронтой байгуулсан эсэх, өнгөрсөн хугацаанд энэ төрлийн хэлэлцээрийг хэрхэн ашигласан, ямар үр дүнд хүрсэн, энэ төрлийн хэлэлцээрийн дагуу авлигатай тэмцэх болон Засгийн газраас хэрэгжүүлж буй "5 Ш" ажиллагаатай холбоотойгоор тодорхой үйл ажиллагаа явуулсан эсэх, тодорхой этгээдийг шилжүүлэх, авчрах хоёр улсын хоорондын ялтан шилжүүлэх ажиллагаа хийгдсэн эсэх, Бүгд Найрамдах Чех Улсад гэмт хэргийн улмаас хохирсон Монгол Улсын иргэн байгаа эсэх талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал хэлэлцээрийн төслийн хавсралт дахь нууцын зэрэглэл тогтоосон заалттай холбогдуулан Чехийн талаас шилжүүлэн өгсөн хязгаарлагдмал мэдээллийг Монголын тал нууцын зэрэглэлд авч үзэхээр заасан нь оновчтой эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг уг хэлэлцээрийг байгуулснаар Европын улс орнуудад Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах, Европын улс орнуудын туршлагаас суралцах эхлэл болох тул уг төслийг дэмжиж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин Монгол Улс нь хүний эрхийн мэдрэмжтэй хуулийн засаглалд ойртсон Европын улс орнуудтай хамтын хэлэлцээрийг соёрхон баталснаар цагдаагийн байгууллага хууль сахиулах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд бүхий л холбогдох байгууллагуудын соёл солилцох, арга барилд суралцах, хүний эрхийг мэдрэмжтэйгээр хамгаалахад, ашиглахад чухал үр нөлөөтэй учраас уг төслийг дэмжиж байгаа бөгөөд мөрдөн шалгах ажиллагааны нууцтай холбоотой Эрүүгийн хуулийн холбогдох зохицуулалтыг сайжруулах шаардлага байгаа тул уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хийхдээ хэлэлцээрийг төслийг холбогдох зохицуулалттай нийцүүлэх талаар анхаарах, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд хэлэлцээрийн төслийн орчуулга оновчтой эсэх, Монгол орчуулгын үг хэллэг, эрх зүйн түгээмэл нэр томъёонд хэрэглэгдээгүй хэллэг ашигласан, нэг заалтад хоёрдмол утга илэрхийлсэн, хэл зүйн найруулгын хувьд засаж сайжруулах шаардлага байгаа тул төслийг Англи болон Монгол хэл дээрх эхийн орчуулга нягтлах нь зүйтэй талаар, түүнчлэн зарим төрлийн гэмт хэргийн зөрчлийг Европын 27 улсын стандартад нийцүүлэх талаар ямар зохицуулалт хийхийг анхаарах нь зүйтэй талаар үг хэлсэн.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хэлэлцээрийн дагуу мэргэжилтнүүдийг бэлтгэх, боловсон хүчнийг солилцох, шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчдыг бэлтгэх асуудлаар Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам төлөвлөгөө гаргах, төсвийг хуваарилах, бодит ажил болгох тал дээр онцгой анхаарах, түүнчлэн тодорхой гэмт хэргийг нэрлэн заасныг анхаарч, цахим гэмт хэрэгтэй тэмцэхэд Европын улс орнуудын туршлагаас суралцах нь зүйтэй гэсэн талаар санал хэлсэн болно.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улсын хоорондын хэлэлцээр”-ийн төслийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 75 хувь нь зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хэлэлцүүлэхээр шийдвэрлэлээ.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас “Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улсын хоорондын хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Ингээд хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүд байна уу? Нэрсийг авъя.

Байхгүй байна уу?

Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу?

Үг хэлэх гишүүд алга байна.

Санал хураалтыг явуулж эхэлье.

“Цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя.

Гишүүд байранд. Санал хураалтыг явуулъя.

Санал хураалт 69.2 хувиар дэмжигдлээ.

Уг асуудлыг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлнэ.

Уг хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны өнөөдрийн, айн? Батсүмбэрэл гишүүн дэмжсэн байна. Дэмжсэнээр протоколд авъя.

Ингээд Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Хүрэлцэн ирсэн гишүүдэд баярлалаа.

12.23 цаг

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.ОТГОНДЭЛГЭР

